

**БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХҮНИЙ  
ЭРХ ЗӨРЧИГДӨХӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ, ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ  
СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨ (2023-2027)**



# Агуулга

- 01 Үндэслэл, шаардлага
- 02 Зорилго, зорилт
- 03 Төрийн үүрэг, хариуцлагыг сайжруулах арга хэмжээ
- 04 Бизнес байгууллагын үүрэг, хариуцлагыг сайжруулах арга хэмжээ
- 05 Зөрчигдсэн эрхийг сэргээх талаарх арга хэмжээ
- 06 Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах арга хэмжээ



1

Үндэслэл, шаардлага

# Ач холбогдол

- Бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах,
- Хүний эрхийн хэм хэмжээг бизнесийн салбарт нэвтрүүлэх,
- Төр, орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулах,
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргах,
- Монгол Улсын болон бизнес эрхлэгчдийн олон улсад өрсөлдөх нэр хүнд, чадварыг нэмэгдүүлэхэд онцлох ач холбогдолтой.



Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрөөс **хүний эрх, эрх чөлөөг** хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, **хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх** үндэсний тогтолцоог бэхжүүлэх, олон талт түншлэлийг хөгжүүлэх, хүний эрхийн стандартыг нэвтрүүлэх зорилтыг хэрэгжүүлж, **хүний эрхийг хүндэтгэсэн бизнесийн соёлыг** нутагшуулахад бодит түлхэц болно.

# Төлөвлөгөө баталсан үндэслэл, шаардлага

## Ач холбогдол бүхий баримт бичгүүд

**Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, 2003**

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага нь эдийн засгийн ололт, нийгмийн хөгжилд даацтай хувь нэмэр оруулахын зэрэгцээ өөрсдийн ажиллагчдын төдийгүй бусад хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бэхжүүлэхэд дорвитой үүрэг гүйцэтгэх учиртай.

**“Алсын хараа- 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг**

Монгол Улсад 2050 он гэхэд нийгмийн бүх харилцаанд хүний эрхийг бүрэн хангасан тогтолцоог төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

**НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс баталсан Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд & НҮБ-ын ХЭЗ-с өгсөн зөвлөмж**

- Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2011 онд бизнесийн үйл ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хүрээг тодорхойлсон 31 зарчим бүхий “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд” баримт бичгийг батлан гаргасан.
- НҮБ-ын ХЭЗ-с 4.5 жил тутам хийгддэг Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс МУ-ын ЗГ-т өгсөн зөвлөмж.

# Бүтэц



## Нийтлэг үндэслэл

1

Хүний эрхийг хангах, хамгаалах талаарх **төрийн үүрэг**, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

2

Хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх, хангах талаар **аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг**, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

3

**Зөрчигдсөн эрхийг сэргээх**, хохирлыг барагдуулах хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх, үр нөлөөг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

4

Төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэр

5

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх


6

A large, white, stylized number '2' is positioned on the left side of the image. The background is a blue-tinted aerial view of a city with various buildings and a prominent curved glass skyscraper. The overall mood is professional and modern.


2

Зорилго, зорилт


# Зорилго



Монгол Улсад хүний эрхийг хүндэтгэсэн бизнесийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах



Бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх зөрчигдөх, хүрээлэн буй орчинд үүсэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах



Зөрчигдсэн эрхийг сэргээхтэй холбоотойгоор хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, төлөвлөх, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, хэрэгжүүлэх



# Зорилт



Өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, эрх нь зөрчигдөх эрсдэлтэй бүлгийн эрх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг дэмжих;



Өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах үндсийг бүрдүүлэх, бэхжүүлэх;



Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагаанд хүний эрхийн зарчим, шалгуур үзүүлэлтийг баримтлах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;



Өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгж бизнесийн үйл ажиллагаандаа хүний эрхийн магадлан шинжилгээ (**ХЭМШ**) хийх эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;



Хүний эрхийг хүндэтгэсэн бизнесийн соёлыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд олон нийт, хувийн хэвшлийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх;



Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, нийгэм, эдийн засгийн нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих;



Зөрчигдсөн эрхийг шүүхийн болон шүүхийн бус журмаар сэргээх, хохирлыг барагдуулах журам, механизмыг бэхжүүлэх, баталгаажуулах.

A large, white, stylized number '3' is positioned on the left side of the image. The background is a blue-tinted photograph of a modern office meeting. Several people are seated around a long table, engaged in discussion. The office has large windows and modern furniture.

3

Төрийн үүрэг хариуцлагыг  
сайжруулах арга хэмжээ

1-р тулгуур багана

# Хэрэгжүүлэх арга хэмжээ

1

Олон улсын гэрээнд нэгдэн орох

2

Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо хүний эрхэд суурилсан хандлагад үндэслэн төлөвлөх, хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, бэхжүүлэх

3

Өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгжийн хүний эрхийг хүндэтгэн сахих талаарх үүрэг, хариуцлагыг бэхжүүлэх

4

Өмчийн аливаа хэлбэрийн аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа хүний эрхийн магадлан шинжилгээ хийдэг байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх

5

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хөгжлийн томоохон төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагаанд хүний эрхийн зарчим, шалгуурыг баримтлах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх

6

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг сайжруулах

7

Албадан хөдөлмөр, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

8

Хөдөлмөр эрхлэлт, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтыг арилгах, амьжиргаанд хүрэлцэхүйц цалин хөлс авах, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах

9

Иргэдийн эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангагдах эрхийг хангах

10

Уул уурхай, олборлолт, дэд бүтцийн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хүний эрхийн зарчим, шалгуурыг харгалзах хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, олон нийтийн оролцоог хангах

11

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, уул уурхай, олборлолт, хүнд үйлдвэрлэл, зам тээвэр, эрчим хүчний дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэхэд хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх, хөрөнгийг үнэлэх, нөхөн олговор олгох хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх

12


Албан бус эдийн засагт ажиллагсдыг албан хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх замаар эрхээ эдлэх, хамгаалуулах боломжийг бүрдүүлэх

13

Хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх

14

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, ээлтэй орчныг бүрдүүлж, эдийн засгийн идэвхтэй гишүүн болгох



# Хэрэгжүүлэх арга хэмжээ

ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ
<p>Хүний эрхэд суурилсан хандлагаар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, түүний эрх зүйн үндсийг бүрдүүлэх</p>	<p>Энэ талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, дүгнэлт, санал боловсруулах, цаашлаад ийнхүү хүний эрхэд суурилсан хандлагад үндэслэн боловсруулах, үнэлэх аргачлал-удирдамж бэлтгэх, сурталчлан таниулах, төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх</p>
<p>Аж ахуйн нэгжийн хүний эрхийг хүндэтгэн сахих талаарх үүрэг, хариуцлагыг бэхжүүлэх</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрхэд сөрөг нөлөө учруулах, зөрчил гаргахаас сэргийлэх, зөрчлийг арилгах талаар бизнес байгууллагын хүлээх үүрэг хариуцлагыг хууль тогтоомжид тусгах</p> <p><b>Бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, зөрчлийг илрүүлэх, үнэлэх, хянах, хариуцан арилгуулах үүргийг тодорхойлж хууль тогтоомжид тусгах</b></p>
<p>Аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа <b>ХЭМШ</b> хийх эрх зүйн үндсийг бүрдүүлэх</p>	<p><b>ХЭМШ хийх удирдамж, аргачлал боловсруулах, сурталчлан таниулах, чадавх бэхжүүлэх</b></p> <p>Төр, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагад төсөл хэрэгжүүлэх, ХЭМШ хийсэн тайлан мэдээллийг олон нийтэд танилцуулах</p> <p><b>Бизнесийн үйл ажиллагаа болон ханган нийлүүлэлтийн сүлжээнд ХЭМШ хийдэг байх хууль, эрх зүйн орчныг бий болгох талаар судалгаа хийж, дүгнэлт, санал боловсруулах</b></p> <p>Эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад ХЭМШ хийхэд дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлэх, эдгээр байгууллагын хүний эрхийг хамгаалах үүргийг хуульд нарийвчлан тусгах</p>



# Хэрэгжүүлэх арга хэмжээ

ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ
<p>Төр, орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хүний эрхийн зарчмыг баримтлах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх</p>	<p>Энэхүү ажиллагаанд хүний эрхийн шалгуур үзүүлэлтийг харгалзах, ялангуяа нийлүүлэгч, гүйцэтгэгчид тавигдах үндсэн шаардлагад хүний эрхийн шалгуурыг харгалзах зохицуулалтыг бий болгох судалгаа хийх, хууль тогтоомжид тусгах</p> <p>Төр, хувийн хэвшлийн түншлэл болон хөрөнгө оруулалтын гэрээнд байгаль орчин, хүний эрхийн чиглэлээр хүлээх үүргийг хууль тогтоомжид тусгах</p>
<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг сайжруулах</p>	<p><b>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх стандартуудыг шинэчлэх</b>, холбогдох конвенциудын зохицуулалт болон дотоодын хууль тогтоомжийн нийцэл, уялдаа холбоог үнэлж, шаардлагатай өөрчлөлтийг тусгах</p> <p><b>Уул уурхай, барилга, зам тээвэр зэрэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол өндөртэй салбар дахь байгууллагуудад шалгалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, зөрчлийг арилгуулах</b></p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх ажил олгогч, ажилтны ойлголтыг нэмэгдүүлэх, ажлын байрны орчин, цаг, ачааллын хуваарилалт зэргийн талаар мэдээлэл, зөвлөмж өгөх үйл ажиллагаа зохион байгуулах</p> <p>Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг бүртгэх дүрэм, цахим системийг сайжруулж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар, хороо, зөвлөлийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох үнэлгээ хийж, чадавхыг бэхжүүлэх</p>



# Хэрэгжүүлэх арга хэмжээ

ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ
Албадан ба хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг хориглосон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	<p>Холбогдох конвенцын зохицуулалт дотоодын хууль тогтоомжийн нийцлийг үнэлж, нийцлийг хангах арга хэмжээ авах</p> <p>Хориглосон ажлын байранд хүүхэд ажиллуулсан зөрчлийг илрүүлэх, хяналт шалгалт тогтмол хийх, зөрчлийг арилгуулж, албадан болон хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн талаарх ажил олгогч, ажилтны ойлголтыг сайжруулах үйл ажиллагаа явуулах</p>
Хөдөлмөр эрхлэлтэд холбоотой эрхүүдийг хангах	<p>Холбогдох конвенцын зохицуулалт дотоодын хууль тогтоомжийн нийцлийг үнэлж, нийцлийг хангах арга хэмжээ авах</p> <p>Цалингийн бүтцийн судалгааг хийж, цалин хөлсийг шударга, амьжиргааны өртөгт тохирсон байхаар тохируулж, тогтоох аргачлал боловсруулах, сурталчлан таниулах, хэрэгжүүлэх</p> <p>Эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхийг хангах хүрээнд аргачлал, заавар боловсруулж таниулах, ажил олгогч, ажилтны ойлголтыг нэмэгдүүлэх, үүрэг, хариуцлагыг сайжруулах ажиллагаа зохион байгуулах</p> <p>Үйлдвэрчний эвлэлийн хороод бие даан, хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон талт хэлэлцүүлгүүд зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргах, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийг (1991) шинэчлэх</p>



# Хэрэгжүүлэх арга хэмжээ

ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ
Иргэдийн эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангагдах эрхийг хангах	“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36-р тогтоолын хэрэгжилтийг хангах, <b>хүнсний үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын дотоод хяналтын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах</b>
Уул уурхай, дэд бүтцийн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хүний эрхийн зарчмыг харгалзах, олон нийтийн оролцоог хангах	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам болон байгаль орчны үнэлгээний талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх, санал гаргах боломжийг бүрдүүлэх, олон нийтийн санал туссан эсэхийг эргэж мэдээлэх байдлаар олон нийтийн оролцоог хангах  Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас хүний эрхэд учирч байгаа сөрөг нөлөөллийн талаар дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээ авах
Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах	Уул уурхай, зам, тээвэр, хүнд үйлдвэрлэлийн идэвхтэй бүс нутагт байгаа иргэдийн эрхийг хамгаалах зорилгоор тухайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсийг тодорхойлох, эрхийг хамгаалах, сөрөг нөлөөллөөс сэргийлэх, хянах, арилгах талаар төрийн байгууллага болон бизнес байгууллагын үүрэг, хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авах  Газар чөлөөлөх, нүүлгэх, албадан нүүлгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, иргэдийн газар өмчлөх эрхийг хамгаалах, өмч хөрөнгийг үнэлэх, нөхөн олговор тооцох журмыг сайжруулах  Хот төлөвлөлт, зохион байгуулалт, олон нийтийн үйлчилгээтэй холбогдох хууль тогтоомжид хүний эрхэд суурилсан хандлагын үүднээс үнэлгээ хийж, боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах, зөрчилд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх

# Хэрэгжүүлэх арга хэмжээ

ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ
Хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх	<p>Хөдөлмөр эрхлэгчдийн эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, нийгмийн хамгааллын талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийг татан оролцуулах</p> <p>Хөдөлмөрийн харилцааны талаар хууль зүйн мэргэшсэн туслалцаа үзүүлэх хуульчдыг бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх</p>
Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, ээлтэй орчныг бүрдүүлж, эдийн засгийн идэвхтэй гишүүн болгох	<p>25, түүнээс дээш ажилтантай байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг төлж байгаа эсэхийг шалгах. <b>Хэрэв ажиллуулдаг бол жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх санхүүгийн зээл, хөнгөлөлтөд хамруулах боломжийг нэмэгдүүлж</b>, эдгээр байгууллагад хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах</p> <p>Томоохон худалдааны төв, үйлчилгээний байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүн саадгүй нэвтрэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд үйлчилгээний байгууллагуудад мэргэшсэн байгууллагаар үнэлгээ хийлгүүлж, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх</p>






# 4

Бизнес байгууллагын үүрэг,  
хариуцлагыг сайжруулах  
арга хэмжээ

2-р тулгуур багана

# Хэрэгжүүлэх арга хэмжээ



- 01 Зорилт**  
НҮБ-ын “**Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд**” болон НҮБ-ын Хүний эрх, үндэстэн дамнасан корпорациуд болон бусад бизнесийн аж ахуйн нэгжийн асуудлаарх Ажлын хэсгээс гаргасан “**Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын жөндөрийн хүрээ**” гарын авлагыг сурталчлан таниулах
- 02 Зорилт**  
Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах талаар аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлагыг сайжруулах
- 03 Зорилт**  
Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх
- 04 Зорилт**  
Хүний эрхийг хүндэтгэн ажиллах бизнесийн соёл, хандлагыг нутагшуулж ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг **урамшуулах**, хөхиүлэн дэмжих тогтолцоог хөгжүүлэх
- 05 Зорилт**  
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах

# Хэрэгжүүлэх арга хэмжээ

ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ
<p>Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд болон Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын жендэрийн хүрээ гарын авлагыг сурталчлан таниулах</p>	<p>Эдгээр баримт бичгийг бизнесийн байгууллага, ажилтан, мэргэжлийн холбоод, олон нийтэд сурталчлан таниулах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд туслах <b>зөвлөмж, гарын авлага, материал боловсруулах, түгээх</b></p>
<p>Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах талаар бизнес байгууллагын үүрэг, хариуцлагыг сайжруулах</p>	<p>Байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчлийг илрүүлж арилгах, шийдвэрлэх талаар бизнесийн байгууллагын үүсгэн байгуулагч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага, ойлголтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах, <b>бодлогын баримт бичиг гаргаж хэрэгжүүлэхийг</b> уриалах</p> <p>Байгууллагууд <b>цахим орчинд хүний эрхийг хүндэтгэх</b> соёл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн ажил зохион байгуулах, энэ чиглэлээр бодлогын баримт бичиг гаргаж хэрэгжүүлэхийг уриалах</p>



# Хэрэгжүүлэх арга хэмжээ

ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ
ХЭМШ хийх чадавхыг бэхжүүлэх	<p>ХЭМШ хийдэг тогтолцооны хэлбэрүүдийг судалж, сурталчлан таниулах</p> <p>Үйл ажиллагаандаа бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах бодлого нэвтрүүлсэн, <b>ХЭМШ, эрсдэлийн үнэлгээ хийсэн байгууллагын туршлагыг хуваалцах, сурталчлах</b>, энэ талаар сургалт зохион байгуулах,</p> <p>ХЭМШ хийх үйлчилгээ үзүүлдэг зөвлөх үйлчилгээний компани, нөхөрлөл байгууллагыг чадавхжуулах, хүний эрхийн магадлан шинжилгэ хийх системийг нэвтрүүлэх, нутагшуулахад татан оролцуулах</p>
Хүний эрхийг хүндэтгэн ажиллах бизнесийн соёл, хандлагыг нутагшуулж буй бизнесийн байгууллагыг урамшуулах, дэмжих тогтолцоог хөгжүүлэх	<p>Өөрийн үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэх соёл, хандлагыг нэвтрүүлж, ханган нийлүүлэлтийн сүлжээнд таниулан тархааж буй байгууллагыг <b>шалгаруулах, сайн туршлагыг сурталчлан дэмжих</b></p> <p>Хүний эрхийг хангах, хамгаалах бодлого нэвтрүүлж, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлдэг байгууллагыг урамшуулах, дэмжих арга хэрэгслийг (тухайлбал, <b>татварын хөнгөлөлт, хөнгөлөлттэй зээл, бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад зах зээлд сурталчлах</b>) бий болгох асуудлаар судалгаа хийж, санал боловсруулах</p>



# 5

Зөрчигдсөн эрхийг сэргээх  
талаарх сайжруулах арга  
ХЭМЖЭЭ

3-р тулгуур багана

# Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Хөдөлмөрийн маргааныг урьдчилсан журмаар хянан шийдвэрлэх тогтолцоо, механизмыг сайжруулах

2. Хөдөлмөрийн маргаан, хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол, маргаан шийдвэрлэх хувийн хэвшлийн механизмыг хөхиүлэн дэмжих, бэхжүүлэх


7. Иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх

3. Салбарын мэргэжлийн холбоод гомдол, маргаан шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үндсийг бүрдүүлэх, чадавхыг бэхжүүлэх

6. Хүний эрхийн Үндэсний комиссын гомдол, маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг бэхжүүлэх


4. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх

5. Хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгохтой холбоотой хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх



# Хэрэгжүүлэх арга хэмжээ

ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ
<p>Хөдөлмөрийн маргааныг урьдчилсан журмаар хянан шийдвэрлэх тогтолцоо, механизмыг сайжруулах</p>	<p>Хөдөлмөрийн зуучлагч, Хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороогоор маргаан шийдвэрлэх талаар таниулах, эдгээр байгууллагуудын чадавхыг сайжруулах хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах</p>
	<p>Байгууллага дэргэдээ хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс байгуулсан эсэхэд хяналт шинжилгээ хийж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах</p>
	<p>Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах төрийн албан хаагчдын мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх</p>
	<p>Хөдөлмөрийн маргаан, түүний шийдвэрлэлтийг бүртгэх мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, дүн шинжилгээ хийх, маргааны шалтгаан нөхцөлийг арилгах бодлогын арга хэмжээ авах</p>
<p>Хөдөлмөрийн болон хүний эрхийн талаарх гомдол, маргаан шийдвэрлэх хувийн хэвшлийн механизмыг дэмжих</p>	<p>Хөдөлмөр эрхлэлт болон бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэх дотоод механизм бий болгох талаар зөвлөмж, гарын авлага боловсруулж, сурталчлах,</p>
	<p>Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс байгуулахад бизнес байгууллагад арга зүйн дэмжлэг үзүүлэх, комиссын маргаан шийдвэрлэх ажиллагаанд үр нөлөөний үнэлгээ хийж, боловсронгуй болгох арга хэмжээ авах</p>
	<p>ХЭМШ, эрсдэлийн үнэлгээгээр илэрсэн хүний эрхийн зөрчлийг арилгах, зөрчигдсэн эрхийг ил тод үр дүнтэйгээр сэргээх, хохирлыг барагдуулах талаар заавар, зөвлөмж боловсруулах, түгээх</p>



# Хэрэгжүүлэх арга хэмжээ

ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ
<p>Салбарын мэргэжлийн холбоод гомдол, маргаан шийдвэрлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх үндсийг бүрдүүлэх, чадавхыг бэхжүүлэх</p>	<p>Салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд тухайн салбарын байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн сөрөг нөлөөллийг бууруулах, зөрчлийг арилгах, зөрчигдсэн эрх сэргээх механизмыг бий болгох талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, зөвлөмж гаргах, мэргэжлийн холбоодын гомдол, маргаан хянах чадавхыг бэхжүүлэх</p>
	<p>Маргаан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулахад шаардлагатай программ хангамж, дэд бүтцийг бүрдүүлэх суурь судалгаа, тооцооллыг боловсруулж, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, маргаан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох</p>
<p>Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх</p>	<p>Шүүхээс нэхэмжлэл буцаах нөхцөлийг бууруулах зорилгоор иргэн, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах талаар хууль тогтоомжид тусгах</p> <p>Уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуйн салбарын байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлийн талаарх хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг боловсронгуй болгох</p> <p>Бизнес ба хүний эрхийн асуудлаар прокурор, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын мэдлэг, ойлголтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах</p> <p>Эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг хөгжүүлэх, шийдвэрийг баталгаажуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх талаар судалгаа, дүгнэлт гаргах, эвлэрүүлэн зуучлагчдыг чадавхжуулах, урамшуулах тогтолцоог бий болгох</p>





# Хэрэгжүүлэх арга хэмжээ

ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ
Хохирлыг барагдуулах, нөхөн төлөхтэй холбоотой эрх зүйн орчныг бэхжүүлэх	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний нөхөн төлбөрийн талаар ажил олгогч, ажилтны мэдлэг, ойлголтыг сайжруулах  Хохирол тооцох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох,
Хүний эрхийн Үндэсний Комиссын гомдол, маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг бэхжүүлэх	Хүний эрхийн Үндэсний Комисс бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй эрхийн зөрчлийн талаар гомдол хүлээн авах, шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх





6

Төлөвлөгөөний  
хэрэгжилтийг хангах арга  
ХЭМЖЭЭ

# Төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих ажиллагаа

Төрийн байгууллагууд хариуцсан ажил, арга хэмжээний биелэлтийг гаргаж, жил бүрийн **12 дугаар сарын 1-ний** дотор Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албанд хүргүүлнэ.

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба нь төлөвлөгөө хэрэгжиж эхэлснээс хойш **18 сараас доошгүй** хугацааны дараа явцын үнэлгээ (эсвэл хөндлөнгийн үнэлгээ) хийлгэж, цаашид авах арга хэмжээний саналын хамт тухайн жилийн 12 дугаар сарын 10-ны дотор Засгийн газарт танилцуулна.

Ажлын алба нь төлөвлөгөө хэрэгжиж дуусах хугацаанаас **6 сарын өмнө** эцсийн үнэлгээ хийлгэнэ. Үр дүнг Засгийн газар, олон нийтэд мэдээлнэ.

Эцсийн үнэлгээний дүнд төлөвлөгөөг **шинэчлэн боловсруулах, батлуулах,** хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

